



## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.04.25 № А-1/1692  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас зарласан ХААБ/20240103047 дугаартай “Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад захиалагч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Дээрх тодруулга ирсэнтэй холбоотой тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд :

- ТШЗ 26.1. “Огноо: 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр. Цаг: 11 цаг 00 минут” гэснийг “Огноо: 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдөр. Цаг: 11 цаг 00 минут” гэж;
- ТШЗ 26.2. “Огноо: 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр. Цаг: 11 цаг 10 минут” гэснийг “Огноо: 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдөр. Цаг: 11 цаг 10 минут” гэж тус тус өөрчлөв.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д дээрх өөрчлөлтийг тусгасан тендерийн баримт бичгийг шинэчлэн байршуулсан болно.

Хавсралт: 14 хуудастай.



1324024583



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а,  
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381  
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,  
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,  
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2024.04.24 № 01/1415  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ХААБ/20240103047 дугаартай тендер шалгаруулалттай холбоотойгоор уг тендер шалгаруулалтыг сонирхогч "Тайгын хийц" ХХК-ийн гаргасан 4 дэх удаагийн тодруулгыг танай 2024 оны А-1/1585 дугаар албан бичгээр уламжлан ирүүлсэнтэй танилцлаа.

Уг тодруулгад өмнөх 3 удаагийн тодруулгатай агуулгын хувьд ижил тодруулга ирүүлсэн гэж үзэж байна. Нэмэлтээр тодруулгад ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай дурдсан байна. Ийм зөрчил үүссэн эсэх нь тендерийн үнэлгээний хороонд орохоос эхлээд мэдэгдлээ өгснөөр илэрхийлэгдэж байгаа бөгөөд үүсэх эсэх нь тендер нээсний дараагийн шатанд илэрхийлэгдэх тул урьдчилсан дүгнэлт хийж байгааг эсэргүүцэж байна.

Мөн хавсралтаар хүргүүлж буй өмнөх 3 удаагийн тодруулгын хариулттай сайтар танилцахыг зөвлөмж болгож байна.

Нэг аж ахуй нэгж ижил агуулга бүхий тодруулгыг олон дахин ирүүлж, тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны гишүүдэд хөндлөнгөөс нөлөөлөх үйлдэл гаргаж, улмаар тендер шалгаруулалтын шаардлага, ажлын даалгавартай уялдаагүй, төрийн захиргааны төв байгууллагын дотоод үйл ажиллагаа, бодлого зохицуулалтын арга хэмжээтэй холбогдох асуулт ирүүлж байгаа нь төрийн ажлыг санаатайгаар тасалдуулах, зогсоох оролдлого гэж үзэж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Иймд дээрх тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж ажиллахыг хүсье.

Хавсралт 7 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Г.САРАН

1301051898

## ҮХЭР СҮРГИЙГ ЯЛГАН ТЭМДЭГЛЭЖ, МАЛЫН ҮНДЭСНИЙ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ БҮРДҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД ИРҮҮЛСЭН ТОДРУУЛГЫН ХАРИУ

### Тодруулга – 1.1.

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.9.а-д төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд захиалагч байхаар, 45.7-д төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлж болно гэж тус тус заасны дагуу энэхүү тендер шалгаруулалтыг зарласан болно" гэсэн өгүүлбэрт болно гэх үгийг болж хэмээн алдаатай бичсэн тул дээрх тайлбарыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.9 а-д төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд захиалагч байхаар, 45.7-д төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлж болно гэж тус тус заасны дагуу энэхүү тендер шалгаруулалтыг зарласан болно" гэж ойлгоно.

### Тодруулга – 1.2.

Монгол Улсын засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 424 дүгээр тогтоолоор "Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс"-ийг олон улсын шаардлагад нийцүүлэн 5 аймагт байгуулах, 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн "Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай" 233 дугаар тогтоолд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдаалах, дундын зуучлалгүйгээр малчдаас хэрэглэгчдэд шууд хүргэх боломжийг хангах тухай тус тус заасан.

### Тодруулга – 1.3.

Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах ажлыг 2023 онд мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулахаар заасан 5 аймагт хийхээр төлөвлөсөн боловч мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний технологит хугацаа өнгөрсөн тул 2024 онд хийхээр төлөвлөж, зохион байгуулж байна.

### Тодруулга – 2.1

Монгол Улсын засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 424 дүгээр тогтоолоор "Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс"-ийг олон улсын шаардлагад нийцүүлэн 5 аймагт байгуулах, 2023 оны 06 дугаар сарын 21-ны

өдрийн “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” 233 дугаар тогтоолд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдаалах, дундын зуучлалгүйгээр малчдаас хэрэглэгчдэд шууд хүргэх боломжийг хангах тухай тус тус заасан.

#### Тодруулга – 2.2, 2.3

Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.9-д “малчин, мал бүхий этгээд холбогдох журам, зааврын дагуу малыг ялган тэмдэглэх, сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасгийн нэгдсэн бүртгэлд хамруулах үүрэгтэй” гэж заасан тул Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хорооны гишүүд тус хуулийн 11 дүгээр зүйлд заасан мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжээр гүйцэтгүүлэхгүй байж болно гэж үзэн дээрх ажлын даалгаварт заасан заалтыг өөрчлөх шийдвэр гаргасан болно.

Мөн Малын генетик нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д “Мэргэжлийн зэрэг, дэв, итгэмжлэл олгох, хүчингүй болгох, сунгах, бүртгэх болон мөн энэ хуулийн 10.8-д заасан урамшуулал олгох журмыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан. Дээрх заалтын дагуу журам боловсруулах явцад итгэмжлэл гэдэг үг нь мэргэжилтнийг итгэмжлэх, эсвэл нэгжийг итгэмжлэх гэсэн утга санааны хувьд давхардаж байгаа тул журам батлуулахаар төсөл хэлэлцүүлэх явцад хэд хэдэн удаа зарчмын зөрүүтэй санал гарсан тул журмыг батлах боломжгүй байдалд хүрсэн болно. Иймд хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах үүрэгтэй тул дээрх хуулийн заалтыг зөрчиж болох эсэх тухай ХЗДХЯ-аас тодруулга авах шаардлагагүй гэж үзсэн. Таны тодруулгад дурдсан ХХААХҮЯ-ны сайдын ажлын албаны зөвлөл гэх бүтэц манай байгууллагад байхгүй болохыг анхаарна уу.

#### Тодруулга – 2.4

Малын генетик нөөцийн тухай хууль, Монгол Улсын Их хурал, засгийн газраас гаргасан салбарын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ авах тухай хуулийн хүрээнд “Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх” ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.

Жич: Өмнөх 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 01/1078 дугаар албан бичигт дор дурдсаны дагуу дэлгэрүүлэн тайлбар хүргүүлсэн болно.

(Хуулийн хүрээнд Тодруулга-4:)

*“Тендерийн баримт бичгийн ажлын даалгавар хэсэгт ишлэгдсэн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Мал эмнэлгийн дээгдэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 424 дүгээр тогтоол нь улсын хөгжлийн урт болон дунд хугацааны дараах бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхээр чиглэгдсэн.*

*Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг "Алсын хараа 2050"-ийг 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8.3.14 дэх заалтад "Малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг үнэлэх, бүртгэх, тогтвортой ашиглах, хамгаалах, судлан хөгжүүлэх үйл ажиллагааны тогтолцоо, төлөвшилтийг бүрдүүлнэ" гэж, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.3.4.2-т мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний хүрээнд төвийн бүсийн үхэр сүргийг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэхээр тус тус заасан байдаг. Иймээс тендер шалгаруулалтаар зөвхөн Засгийн газрын 2022 оны "Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 424 дүгээр тогтоолд тусгагдсан аймаг, сумыг хамруулна гэж ойлгож болохгүй юм. ХХААХҮЯам нь Мал аж ахуйг хөгжүүлэхээр гаргасан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийг үйл ажиллагаандаа тусган бүрэн хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд Хөвсгөл аймгийн бүх сумдын үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх арга хэмжээг "Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх" тендер шалгаруулалтад тусгасан.")*

Тодруулга – 3.1, 3.2

Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ХААБ/20240103047 дугаартай тендерийг Малын генетик нөөцийн тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 424 дүгээр тогтоол, 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн "Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай" 233 дугаар тогтоол, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг "Алсын хараа 2050", Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хууль, эрх зүй, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд зохион байгуулж байгааг 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 01/1078 дугаар албан бичигт дэлгэрэнгүй тайлбарлан хүргүүлсэн.

Иймд өмнөх албан бичгийн тодруулгатай сайтар танилцан, дээрх хуулиуд, тэдгээрийг дагалдан гарсан журам, зааврууд болон Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй танилцахыг мэдэгдэж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн  
үйлдвэрийн яамны Төрийн нэрийн  
бичгийн даргын 2024 оны 03 дугаар  
сарын 28-ны өдрийн 01/128 дугаар  
албан бичгийн хавсралт

ҮХЭР СҮРГИЙГ ЯЛГАН ТЭМДЭГЛЭЖ, МАЛЫН ҮНДЭСНИЙ БҮРТГЭЛ  
МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД  
ИРҮҮЛСЭН ТОДРУУЛГЫН ХАРИУ

*Хууль эрх зүйн хүрээнд:*

Тодруулга – 1:

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 424 дүгээр тогтоолоор “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс”-ийг олон улсын шаардлагад нийцүүлэн 5 аймагт байгуулах, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” 233 дугаар тогтоолд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдаалах, дундын зуучлалгүйгээр малчдаас хэрэглэгчдэд шууд хүргэх боломжийг хангах тухай тус тус заасан. Иймд Хөдөө аж ахуйн бирж төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор дээрх тогтоолын хэрэгжилтийг хангахаар мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулахаар заасан 5 аймгийн үхэр сүргийг ялган тэмдэглэж, нэгдсэн бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг компанийн хуримтлагдсан ашгаас сэнхүүжүүлэхээр баталсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.9.а-д төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд захиалагч байхаар, 45.7-д төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлж болж гэж тус тус заасны дагуу энэхүү тендер шалгаруулалтыг зарласан болно.

Тодруулга -2:

Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тендерийн баримт бичгийг Малын генетик нөөцийн тухай хууль болон, холбогдох журам, стандарт болон 2023 онд батлагдсан шинэчлэн батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн баримт бичгийг боловсруулан үнэлгээний хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

Тодруулга – 3:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20 дахь хэсэгт “үйлчилгээ” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан ажил гүйцэтгэхэд хамаарахгүй угсралт, суурилуулалт, туршилт, тохируулгын, эсхүл тусгай мэдлэг, ур чадварын

үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйл ажиллагаа гэж заасан байдаг. Энэхү тендер шалгаруулалтын хийгдэх ажил нь тусгай мэдлэг, ур чадвар шаардах ту үйлчилгээ хэлбэрийг сонгосон болно.

#### Тодруулга – 4:

Тендерийн баримт бичгийн ажлын даалгавар хэсэгт ишлэгдсэн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бү байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 424 дүгээр тогтоол нь улсын хөгжлийн урт болон дунд хугацааны дараах бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх чиглэгдсэн.

Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-ийг 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8.3.14 дэх заалтад “Малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг үнэлэх, бүртгэх, тогтвортой ашиглах, хамгаалах, судлан хөгжүүлэх үйл ажиллагааны тогтолцоо, төлөвшилтийг бүрдүүлнэ” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.3.4.2-т мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний хүрээнд төвийн бүсийн үхэр сүргийг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэхээр тус тус заасан байдаг. Иймээс тендер шалгаруулалтаар зөвхөн Засгийн газрын 2022 оны “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бү байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 424 дүгээр тогтоолд тусгагдсан аймаг, сумыг хамруулна гэж ойлгож болохгүй юм. ХХААХҮЯ-ам нь Мал аж ахуйг хөгжүүлэхээр гаргасан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийг үйл ажиллагаандаа тусган бүрэн хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд Хөвсгөл аймгийн бүх сумдын үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх арга хэмжээг “Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх” тендер шалгаруулалтад тусгасан.

#### Тодруулга -5

Тендерийн үйлчилгээ үзүүлэх хамрах хүрээний 5 аймгийн 73 суманд 2023 оны жилийн эцэст нийт 1,26 сая үхэр сүрэг тоологдсон ч 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлийн улмаас 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 262.2 мянган толгой үхэр хорогдсон мэдээтэй байлаа. Тиймээс тендерээр 1.0 сая толгой үхрийг ялган тэмдэглэхээр тусгасан. Тендер шалгаруулалтын явцад малын хорогдол гарсаар байгаа бөгөөд шалгаруулалт дуусч гэрээ байгуулахад үед ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх үхрийн тоо 1.0 саяд хүрэхээргүй бол зохицуулалт хийж ажиллах боломжтой болно.

#### 3. Тендерийн үйлчилгээ үзүүлэх хамрах хүрээний 5 аймгийн үхэр сүргийн тооны өөрчлөлт

№	Аймаг	Сум	2023 оны эцэст тоологдсон үхрийн тоо	2024 оны 03 дугаар сарын байдлаар тодотгосон үхрийн тоо
1	Баян-Өлгий	13	175,530	170,000

2	Увс	19	224,840	211,301
3	Ховд	17	196,190	190,000
4	Хөвсгөл	23	636,990	400,000
5	Дорнод	1	28,700	28,700
Нийт		73	1,262,250	1,000,000

**Тодруулга – 6:**

Тендер шалгаруулалтын ажлын даалгаварт тендерт оролцогч нь Малын генетик нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д заасан мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага гэж тодорхойлсон. Малын генетик нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д заасан Мэргэжлийн зэрэг, дэв, итгэмжлэл олгох, хүчингүй болгох, сунгах, бүртгэх журам нь батлагдаагүй тул итгэмжлэл бүхий мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ мэргэжлийн байгууллага бүртгэгдээгүй байна. Иймд энэ тендер шалгаруулалтад мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага байна гэдэг шаардлагыг ашиглахгүй байхаар шийдвэрлэсэн болно.

**Тодруулга – 7:**

Тендер шалгаруулалтын төсөвт өртөг нь 2.5 тэрбум төгрөг бөгөөд уг батлагдсан төсөвт өртөгт багтаан 1.0 сая үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхээр тооцоолсон. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.13-д заасны дагуу "Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан нөхцөлөөр гэрээний үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай татвар, даатгал, тээвэрлэлтийн болон бусад бүх зардлыг тендерийн үнэд багтсан" гэнэ. ХХААХҮ-ийн сайдын 2018 оны "мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээнд баримтлах жишиг үнэ батлах тухай" А-68 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан хэмжээг улсын төсвөөр санхүүжих үйл ажиллагааг төрийн байгууллагатай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэхэд баримталж байна. Харин хувийн аж ахуйн нэгж мал үржүүлгийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэх тохиолдолд зах зээлийн зарчмаар үнэ тогтоон ажиллах боломжтой.

**Боловсон хүчин хүний нөөц:**

**Тодруулга – 1:**

Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д нөөцийн шаардлага тодорхойлсон хүснэгтийн толгойд албан тушаал гэж Сангийн сайдын 2023 оны "тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай" А/260 дугаар тушаалаар батлагдсан маягт 7-ийн дагуу бичсэн тул үнэлгээний хороо өөрчлөх боломжгүй юм. Иймд түүнийг шаардагдах хүний нөөц гэсэнтэй адил утгатай гэж ойлгоно Түүнчлэн хүний нөөцийн шаардлагад баг тус бүр нэг зөвлөх мал зүйч мэргэжилтэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай байхаар шаардсан нь алдаатай байна. Зөвлөх мал зүйч мэргэжилтэн болон хөдөлмөрийн



аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь баг тус бүрд бус, хамрах хүрээний аймагт тус бүрд 1 шаардана гэж залруулж байна. Шаардлагатай мал зүйч мэргэжилтний хүрэлцээний тухайд Хөдөө аж ахуйн их сургууль 1940 оноос нийт 3500 гаруй мэргэжилтэн бэлтгэсэн байна. Үүнээс 2001 оноос хойш төгссөн, 10 буюу түүнээс дээш жилийн ажлын туршлагатай 600 гаруй мал зүйч мэргэжилтний нөөц байна. Гэхдээ тендер шалгаруулалтаар нэг оролцогчид хамгийн багадаа 297 мал зүйч шаардагдахаар байгаа нь 2-оос дээш оролцогч оролцохоор бол хүний нөөцийн хангамж дутагдах эрсдэлт шаардлага мөн гэж үзээд тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1 дэх Техникийн чадавх болон туршлагын шаардлагын үйлчилгээ үзүүлэх хүний нөөц хэсгийн шаардлагыг дараах байдлаар өөрчилсөн болно. Үүнд:

Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: *“Шаардана”*

Ажил гүйцэтгэгч нь үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг мэргэжлийн талаас нь удирдаж чиглэл өгөх үүрэгтэй бүхий зөвлөх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах ажилтантай байна.

- Зөвлөх нь аймаг тус бүрд 1-ээс доошгүй байх ба магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, мал зүйч түүнтэй адилтгахуйц мэргэжилтэй, мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан, тэргүүлэх болон түүнээс дээш мэргэшлийн зэрэгтэй байна.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь аймаг тус бүрт 1-ээс доошгүй байх ба сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх.

Маягт 7

№	Албан тушаал	Шаардах ажилтны тоо /Баг тус бүрт/	Мэргэжил	Ажлын туршлага
1	Эзэмэглэгч	1	Мал зүйч	2-оос доошгүй жил

1. Нэг суманд 1-2 баг гаргаж ажиллуулахаар тооцож санал болгоно. Баг тус бүрд байх эзэмэглэгч нь мал зүйч мэргэжилтэй байна. Харин мал баригч, бүртгэгч зэрэг үйлчилгээг бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах бусад туслах ажилтны нөөцийг бэлэн байлгах албан мэдэгдэл ирүүлэх бөгөөд мэдэгдэл ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.
2. Ажил гүйцэтгэх баг нь үхэр ялган тэмдэглэх технологийн хугацаатай уялдуулсан календарьчилсан төлөвлөгөөтэй байна. Ажил гүйцэтгэх хугацаанд багтаан үхэр эзэмгэх ажил гүйцэтгэх төлөвлөгөөг ажиллах хүчин, багаж, техник хэрэгсэл зэрэг хүчин зүйлстэй уялдуулан бодиттой боловсруулсан байна. Календарьчилсан төлөвлөгөө ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.

Тодруулга – 2:

Тендерийн баримт бичигт зөвлөх, эзэмэглэгч, бүртгэгчийн ажил гүйцэтгэгч нь мал зүйч мэргэжилтэй байхыг шаардсан. Төрийн худалдан авах ажиллагааны газрын хурлын танхимд 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр болсон уулзалтаар зөвлөх болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь аймаг тус бүрд нэг байж болохоор хэлэлцэн шийдвэрлэсэн. Тиймээс нэг тендер оролцогч

шаардлагын дагуу ихдээ 5 зөвлөх мал зүйч мэргэжилтэн, 5 хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай байна. Харин бусад шаардлагатай хүний нөөцийн шаардлагыг өөрчлөн тодруулга 1 хэсэгт тодорхой тайлбарласныг үзнэ үү.

Монгол Улсын хөдөө аж ахуйн их сургууль 1940-2023 оныг дуустал хугацаанд нийт 3588 мал зүйч мэргэжилтэн төгсгөсөн байна.

#### 1. Малзүйч мэргэжилтэний тоо

№	Малзүйч болон түүнтэй адилтгах мэргэжлээр төгсгөсөн жил	Төгсөгчдийн тоо
1	1940 - 1950	48
2	1951 - 1960	158
3	1961 - 1970	795
4	1971 - 1980	470
5	1981 - 1990	781
6	1991 - 2000	507
7	2001 - 2010	238
8	2011 - 2020	446
9	2021 - 2023	145
Нийт		3588

Үүнээс 2001 оноос хойш 684 мал зүйч мэргэжилтэн төгссөн, зөвлөх мэргэшлийн зэрэгтэй 28, тэргүүлэх зэрэгтэй 45 мал зүйчтэй мэргэжилтэн ажиллаж байгаа тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д өөрчлөн шаардсан нөхцөлийг хангахуйц байна гэж үзэж байна.

#### Тодруулга -3 болон 4

Малыг ялган тэмдэглэж, нэгдсэн бүртгэлд хамруулах ажлыг гүйцэтгэхэд 1 суманд 2 баг гарч ажиллахаар тооцвол нийт 594 ажилтан шаардлагатай байна. Үүнээс мал зүйчтэй мэргэжилтэй 146 эзэмлэгч, 5 зөвлөх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гэрчилгээтэй 5 ажилтан шаардлагатай. Харин мал баригч, бүртгэгч зэрэг бусад туслах ажилчид нь заавал дээд мэргэжил эзэмшсэн байх шаардлагагүй тул орон нутгаас ажиллах боломжтой иргэдийг ажиллуулахад хүний нөөц хангагдана гэж үзэж байна.

Тендер шалгаруулалтын батлагдсан төсөвт өртөгт тендерийн баримт бичгийн ажлын даалгавар хэсэгт заасан гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал болон түүнтэй холбогдох татвар, хураамж зэргийг багтаан тооцсон болно.

#### Тодруулга – 5:

Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д шаардса зөвлөх мал зүйч нь баг тус бүрд биш хамрах хүрээний аймаг тус бүрд 1 байхаа энэхүү тодруулгаар залруулсан тул нийт 5 зөвлөх мал зүйч мэргэжилтэ шаардахаар болсон.

***Төрийн албан хаагчдын компьютер, техник хэрэгсэл, цахим технологий шийдэл:***

Тодруулга-1:

Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн системийг 2021 он, шинэчлэн хөгжүүлж 2022 онд оюуны өмчийн тухай хуулийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нэр дээр оюуны өмчийн гэрчилгээ ав баталгаажуулсан. Тус яам нь уг системийг тасралтгүй хөгжүүлэн, хэвийн ажиллагаа хангаж мал аж ахуйн салбарын суурь мэдээллийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн систем нь мэдээлэл технологийн хөгжил дэвшилтэй уядуулан 100 хувь цахимаа ажиллаж, 21 аймаг, нийслэл, 365 сум, дүүргийн хэмжээнд бүрэн нэвтрээд байна. Орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны албан хаагчид, сум, дүүрэгт Хөдөө аж ахуйн тасагт мал аж ахуйг асуудал хариуцсан албан хаагчид системд хязгаарлагдмал эрхтэйгээр нэвтэрч мэдээллийн санг идэвхтэй ашиглаж байна.

Тодруулга -2 болон 3:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь 2021 онд малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн системийг /livestock.mofa.gov.mn/ 100 хувь цахим болгон шинэчилсэн. Уг системд аймаг, сумын албан хаагчид хязгаарлагдмал эрхээр хандаж ажиллаж байгаа тухай тодруулга 1-д тодорхой дурдсан болно. Түүнчлэн малыг бүртгэлийн ажлыг хялбаршуулах зорилгоор бүх төрлийн үйлдлийн систем, ухаалаг төхөөрөмжид ашиглах боломжтой LHS /мал аж ахуй аппликейшныг хөгжүүлсэн. Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тендерийн баримт бичигт дээрх систем аппликейшн ашиглан шууд бүртгэл хийх болон орон нутгийн хэмжээнд ашиглах техник хэрэгсэл, урьдчилан тооцоолох боломжгүй эрсдэлийг тооцоолон "Бүртгэлийн маяг"-ыг боловсруулан маягтын дагуу малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн системд мэдээллийг нөхөн оруулах боломжтойг тендерийн баримт бичиг тусгасан.

Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 2023 оны эцэст тоологдсон 64.7 сая малыг малчин, мал бүхий этгээдээр бүрэн бүртгэсэн. Уг системээс малчны регистрийн дугаараар хайлт хийхэд уг малчны малын тоо, төрлөөр харагдах боломжтой байна. Энэхүү мэдээллийг ашиглан мал тус бүрийг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх анхан шатны бүртгэл бүрэн хийгдсэн болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан судалгаанд Монгол улс интернэт сүлжээ нэвтэрсэн аймаг, сум багуудын 100 хувь нэвтэрсэн ашиглах боломжтой болсон

***Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолт үзүүлэлт:***

#### Тодруулга – 1:

Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1 дэх заалтаар шаардсан техник хэрэгслийг оролцогч аж ахуйн нэгжид байхаар тусгасан. Тиймээс эдгээр тоног төхөөрөмжийг энэ тендерийн төсөвт өртгөөр худалдан авахаар тооцоогүй болохыг үүгээр мэдэгдэж байна. Тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагатай техник хэрэгслийг бэлэн болгож энэ тухайгаа тендер ирүүлэхдээ нотолсон байхыг шаардана.

#### Тодруулга-2

Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтын ээмэгний техникийн ерөнхий шаардлагад мэдээлэл дамжуулагч RFID гэж заагаагүй бөгөөд энгийн ээмэг ашиглахаар тусгасан. Бод малын ялган тэмдэглэх хэрэгсэл болох ээмэг нь Малын ээмэг 6996:2023 Ерөнхий шаардлага улсын стандартыг болон дараах шаардлагыг хангасан байхыг анхаарна уу.

#### Тодруулга-3

Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтын ээмэгний техникийн ерөнхий шаардлагын 2 дугаар хэсэгт “Малын ээмэг” нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болох бөгөөд тухайн үйлдвэрийн нэр хаяг, үйлдвэрлэгчийн тодорхойлолт, бараа нийлүүлэх эсэх зөвшөөрсөн баримт бичгийг хавсаргахаар тусгасан болно.

#### Тодруулга -4

Олон улсын мал амьтны бүртгэлийн хороо (ICAR) нь 60 гаруй улсын 130 гаруй байгууллагын нэгдсэн гишүүнчлэлтэй төрийн бүс байгууллага болно. Тус хорооны малын ялган тэмдэглэх хэрэгсэл нь үйлдвэрлэгчийн нэрээр байгаа тул Монгол Улсын төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12.4-д “техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно” гэж заасан тул тусгах боломжгүй байна.

#### Тодруулга - 5

Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд шаардлагатай тоног төхөөрөмжийн нэрийг буруу бичсэн байх талтай ч хэрэглэх зориулалтыг тодорхой тусгасан болно. Гэхдээ тодруулгыг хэлэлцээд тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1 дэх Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлагыг дараах байдлаар өөрчилсөн болно. Үүнд:

- Тендерт оролцогч нь шалгарсан тохиолдолд ажлын даалгаварт тусгасан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, машин механизмыг бэлэн байлгаж үйлчилгээг цаг хугацаанд нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган бүрэн хийж гүйцэтгэх баталгааг бичгээр ирүүлнэ. Энэ баталгааг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.

#### Тодруулга -6

Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тендерт оролцогч нь Малын ээмэг MNS 6996:2023 стандартыг шаардлагыг хангасан ээмгийг ашиглах шаардлагатай. Тендерийн баримт бичигт бс малын ээмэгний загвар 1-ийг тусгасан бөгөөд уг загварт универсал бахь ашигла бөгөөд гүйцэтгэгч аж ахуйн нэгж бахийг өөрсдөө сонгон үхрийг ээмэглэж, бүртгэ ажлыг зохион байгуулахаар тусгасныг анхаарна уу.

#### Тодруулга -7

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг нь үндэсний стандартад тавигдаж зарим шаардлага, стандартын төсөл боловсруулах, батлах, хэрэглэх харилцаа зохицуулсан бөгөөд таны дурдсан түр хэрэглэх зөвшөөрлийн тухай заалт байхгүй байна. Дашрамд хэлэхэд Малын ээмэг 6996:2023 улсын стандарт нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасныг баримтлан боловсруулж, батлагдсан болохыг мэдэгдэж байна.

#### Тодруулга – 8:

Тендерийн баримт бичгийн ажлын даалгаврын хэсэгт заасан ээмэгний хэмжээс нь Стандарчлал, хэмжил зүйн газрын даргын 2023 оны "стандарт батлах тухай" С-39 дүгээр тушаалаар батлагдсан Малын ээмэг 6996:2023 улсын стандартын хэмжээ болно. Уг стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10.1-д заасан аргачлалын дагуу боловсруулан батлуулсан. Мөн стандартыг боловсруулахад орон нутгийн мэргэжилтнүүдээс ээмэгний хэлбэр хэмжээ, хийц загвар зэрэгт судалгаа авч, төслийг холбогдох сургалт, эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллагуудаар хэлэлцүүлсэн.

#### Санхүү:

##### Тодруулга-1:

Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022, 2023 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 40 хувь болон түүнээс багагүй байна. Үүнийг дээрх онуудын борлуулалтын орлогын дундаж гэж ойлгох бөгөөд нийлбэр гэж ойлгохгүй болно.

##### Тодруулга-2:

Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх үйлчилгээний батлагдсан төсөвт өртгөөс ажиллах хүчний цалингийн болон бусад зардал санхүүжигдэхээр тусгасан.

##### Тодруулга-3:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн  
үйлдвэрийн яамны Төрийн  
нарийн бичгийн даргын 2024  
оны 04 дүгээр сарын 16-ны  
өдрийн 01/33 дугаар албан  
бичгийн хавсралт

## ҮХЭР СҮРГИЙГ ЯЛГАН ТЭМДЭГЛЭЖ, МАЛЫН ҮНДЭСНИЙ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ БҮРДҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД ИРҮҮЛСЭН ТОДРУУЛГЫН ХАРИУ

### Тодруулга – 1.1:

Тайлбар: Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулах явцад уг ажил нь технологийн богино хугацаанд хийгдэх, техник хэрэгсэл шаардсан, цар хүрээ өргөн тул ТШЗ 18.1-д борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022, 2023 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 40 хувь болон түүнээс багагүй байна гэж олонхын саналаар шийдвэрлэсэн. Тиймээс уг шаардлагыг баримтлан ажиллахыг дахин сануулж байна.

### Тодруулга – 2.1:

Тайлбар: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 17 дугаар зүйлийн 17.2.1-д Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт; мөн 17.2.2-т бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт; ирүүлнэ гэж хуульчилсан байдаг.

Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажил нь хууль, журмаар зохицуулагдсан технологийн шинж чанартай, мэргэжилтний хяналт дор зохион байгуулж, бий болгосон бүртгэл мэдээллийг үндэслэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулалт хийх гол үндэслэл болох тул тус ажлыг үйл ажиллагаа нь тогтворжсон, санхүүгийн болон хүний нөөцийн хувьд чадавхтай, салбарын онцлог, ажиллах аймаг, орон нутгийн талаар зохих түвшний мэдлэг, туршлагатай аж ахуйн нэгж гүйцэтгэх нь зүйтэй гэж үзсэн болно.

### Тодруулга – 3.1, 3.2:

Тайлбар: Монгол улсад малын ээмэгний стандартыг анх 2005 онд батлуулж, улмаар

Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-ийг 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8.3.14 дэх заалтад “Малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг үнэлэх, бүртгэх, тогтвортой ашиглах, хамгаалах, судлан хөгжүүлэх үйл ажиллагааны тогтолцоо, төлөвшилтийг бүрдүүлнэ” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.3.4.2-т мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний хүрээнд төвийн бүсийн үхэр сүргийг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэхээр тус тус заасан байдаг. Иймээс тендер шалгаруулалтаар зөвхөн Засгийн газрын 2022 оны “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 424 дүгээр тогтоолд тусгагдсан аймаг, сумыг хамруулна гэж ойлгож болохгүй юм. ХХААХҮЯам нь Мал аж ахуйг хөгжүүлэхээр гаргасан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийг үйл ажиллагаандаа тусган бүрэн хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд Хөвсгөл аймгийн бүх сумдын үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх арга хэмжээг “Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх” тендер шалгаруулалтад тусгасан.”)

Тодруулга – 3.1, 3.2

Үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ХААБ/20240103047 дугаартай тендерийг Малын генетик нөөцийн тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 424 дүгээр тогтоол, 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” 233 дугаар тогтоол, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хууль, эрх зүй, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд зохион байгуулж байгааг 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 01/1078 дугаар албан бичигт дэлгэрэнгүй тайлбарлан хүргүүлсэн.

Иймд өмнөх албан бичгийн тодруулгатай сайтар танилцан, дээрх хуулиуд, тэдгээрийг дагалдан гарсан журам, зааврууд болон Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй танилцахыг мэдэгдэж байна.